



“ХӨДӨӨ АЖ АХУЙН
ДАВХАР ДААТГАЛ” ХК

МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН 2015 ОНЫ БОРЛУУЛАЛТЫН ТАЙЛАН

**УЛААНБААТАР ХОТ
2015 он**



Агуулга

1. МИД-ын 2015 оны борлуулалтын үр дүн
2. Даатгалын компаниудын борлуулалтын үр дүн
3. Эрсдэл санхүүжүүлэх чадвар
4. Дүгнэлт



1. МИД-ын 2015 оны борлуулалтын үр дүн

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн анхны борлуулалт, МИД-ын арав дахь борлуулалтын улирал 2015 оны 4-р сарын 15-нд 21 аймгийн нийт 330 суманд эхэлснээс хойш 2015 оны 7-р сарын 15 хүртэлх хугацаанд оролцогч даатгагчид болох Бодь, Монгол, Монре, МИГ, Практикал, Тэнгэр даатгалын компаниуд нийт **10,317 малчинтай** Малын индексжүүлсэн даатгал /МИД/-ын гэрээг байгуулж, **1 тэрбум 301 сая** төгрөгийн хураамж төвлөрүүлсэн байна. Даатгуулсан малчин өрх нь нийт малчин өрхийн 7,0%-ийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны даатгуулсан малчин өрхийн тооноос 3,772 өрхөөр буюу 26.7%-аар буурсан байна. Хэдийгээр даатгуулсан малчин өрхийн тоо буурсанч хураамжийн орлогын бууралт нь даатгуулсан малчин өрхийн тооны бууралттай харьцуулбал бага байгаа нь малчид малаа илүү өндөр үнээр үнэлж даатгуулж, чанарын үзүүлэлт дээшилж байгааг харуулж байна.

График №1. МИД-д хамрагдсан малчин өрхийн тоо, малчин өрхөд эзлэх хувь¹




Малын индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүнд хамрагдсан малчин өрхийн тоо, хураамжийн орлогыг 2006 оноос хойш харахад өссөн дүнгээр нийт 94 мянга орчим малчин өрх даатгалд хамрагдсан байна. График 2-т хураамжийн орлогын дүнг харуулав.

¹ 2006-2009 онд даатгалд хамрагдсан малчин өрхийн тоо, борлуулалтын орлогыг авахдаа ҮДБ болон ГХБ-д хамрагдсан малчин өрхийн тоо, ҮДБ ГХБ-ний нийт орлогоор авсан болно.



График №2. МИД-ын бүтээгдэхүүний хураамжийн орлого /сая төгрөгөөр/²



2015 оны нийт хураамжийн орлого, даатгуулсан малчин өрхийн тоог Хүснэгт 2-оос харахад газар зүйн байршил, эрсдэлийн түвшин, малчин өрхийн тооноосоо хамааран харилцан адилгүй хамрагдсан бөгөөд баруун аймгийн нутгаар даатгалд хамрагдсан малчин өрхийн тоо харьцангуй өндөр байна.


Хүснэгт №2. МИД-д даатгуулсан малчин өрхийн тоо, даатгуулсан малын нийт үнэлгээ, хураамжийн хэмжээ /2015 он/

№	Аймаг	МИД-д даатгуулсан малчин өрх	Даатгуулсан малын нийт үнэлгээ	Малчны төлсөн хураамжийн хэмжээ
1	Архангай	602	817,872,418₮	38,192,677₮
2	Баян-Өлгий	242	819,315,263₮	22,681,641₮
3	Баянхонгор	2,630	4,878,388,142₮	330,117,185₮
4	Булган	258	795,599,155₮	32,833,080₮
5	Говь-Алтай	357	1,010,066,245₮	57,420,401₮
6	Говьсүмбэр	23	158,948,310₮	4,821,566₮
7	Дархан-Уул	32	347,196,000₮	6,907,747₮
8	Дорноговь	450	1,833,212,454₮	48,900,587₮
9	Дорнод	184	1,026,677,041₮	31,959,714₮
10	Дундговь	478	1,498,472,750₮	72,369,180₮
11	Завхан	539	903,174,700₮	51,554,365₮
12	Орхон	19	155,251,299₮	5,160,640₮
13	Өвөрхангай	269	479,322,966₮	26,156,674₮
14	Өмнөговь	121	133,105,046₮	5,853,910₮
15	Сүхбаатар	362	1,721,435,590₮	82,360,172₮
16	Сэлэнгэ	233	660,936,231₮	21,675,993₮
17	Төв	432	1,042,547,427₮	49,192,428₮
18	Увс	1,401	3,101,295,400₮	161,432,075₮
19	Ховд	256	1,023,813,225₮	36,833,218₮
20	Хөвсгөл	484	1,193,659,910₮	28,686,824₮
21	Хэнтий	945	4,129,047,648₮	186,414,832₮
	Нийт	10,317	27,729,337,218₮	1,301,524,910₮

² 2006-2009 онд даатгалд хамрагдсан малчин өрхийн тоо, борлуулалтын орлогыг авахдаа ҮДБ болон ГХБ-д хамрагдсан малчин өрхийн тоо, ҮДБ ГХБ-ний нийт орлогоор авсан болно.



График №3. Аймгийн малчин өрхөд МИД-д даатгуулсан малчин өрхийн эзлэх хувь



Аймгуудын даатгуулсан малчин өрхийн нийт малчин өрхөд эзлэх хувийг График №3-аас харж болно. Даатгалд хамрагдсан малчин өрхийн нийт малчин өрхөд эзлэх хувь нь 7% бөгөөд энэ нь өнгөрсөн оноос 2,9%-аар буурсан дүнтэй байна.

Хүснэгт №3. МИД-д хамрагдсан малын тоо(малын төрөл, аймгаар)

№	Аймгийн нэр	Хонь	Ямаа	Үхэр	Адуу	Тэмээ	Нийт
1	Архангай	130,679	34,466	17,801	8,648	71	91,665
2	Баян-Өлгий	37,315	16,493	3,518	1,485	264	59,075
3	Баянхонгор	138,584	454,210	29,684	8,279	385	631,142
4	Булган	17,650	10,534	7,490	2,253	6	37,933
5	Говь-Алтай	21,315	73,060	787	548	-	95,710
6	Говьсүмбэр	1,808	2,515	464	62	-	4,849
7	Дархан-Уул	2,012	1,616	900	9	-	4,537
8	Дорноговь	17,146	50,097	7,123	1,325	291	75,982
9	Дорнод	22,595	14,776	4,502	1,495	23	43,391
10	Дундговь	32,872	56,345	4,723	5,604	17	99,561
11	Завхан	128,451	87,963	3,472	1,511	75	221,472
12	Орхон	1,616	341	138	43	-	2,138
13	Өвөрхангай	45,368	33,495	3,319	4,461	265	86,908
14	Өмнөговь	5,685	27,517	246	836	7	34,291
15	Сүхбаатар	64,424	56,816	15,159	7,052	48	143,499
16	Сэлэнгэ	24,962	7,376	8,269	149	11	40,767
17	Төв	101,934	53,196	13,907	12,118	139	181,294
18	Увс	157,342	138,947	10,708	3,277	204	310,478
19	Ховд	32,775	30,478	1,510	510	27	65,300
20	Хөвсгөл	52,680	21,158	6,144	740	5	80,727
21	Хэнтий	99,363	94,703	39,381	13,691	66	247,204
		1,136,576	1,266,102	179,245	74,096	1,904	2,657,923



2015 онд нийт 2,657,923 толгой мал МИД-д хамрагдсан нь манай улсын нийт 51.9 сая малын 5.1 хувийг эзэлж байна. Даатгалд хамрагдсан малын 42.8 хувийг хонин сүрэг, 47.6 хувийг ямаан сүрэг, 6.7 хувийг үхэр сүрэг, 2.8 хувийг адуун сүрэг, 0.1 хувийг тэмээн сүрэг эзэлж байна. /Хүснэгт №3/ Даатгалд хамрагдаж байгаа малын төрлийг харахад эрсдэлд өртөмтгий байдал болон малын тоогоо харгалзан хонь, ямааг ихэвчлэн даатгалд хамруулж, даатгуулж байгаа тухайн төрөл малынхаа үнэлгээг харьцангуй бага үнэлгээгээр сонгон даатгуулж байна.

2014 онд нэг малчин өрхийн төлсөн дундаж хураамжийн дүн 95,879 төгрөг байсан бол 2015 онд 126,153 төгрөг болж өссөн байна. Даатгалын төлөөлөгчийн дундаж борлуулалт 1,8 сая төгрөгтэй байгаа нь өнгөрсөн жилтэй харьцуулахад 450,000 төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Нэг даатгалын төлөөлөгчийн дундаж борлуулалтын тоо, хураамжийн орлого болон нэг малчин өрхийн төлсөн дундаж хураамжийн дүн (2015 он, аймгаар)


№	Аймгийн нэр	Нэг даатгалын төлөөлөгчийн дундаж борлуулалтын тоо	Нэг даатгалын төлөөлөгчийн дундаж хураамжийн орлого	Нэг малчны төлсөн дундаж хураамж
1	Архангай	15	979,299	63,443
2	Баян-Өлгий	14	1,334,214	93,726
3	Баянхонгор	26	3,205,021	125,520
4	Булган	10	1,313,323	127,260
5	Говь-Алтай	8	1,305,009	160,841
6	Говьсүмбэр	8	1,607,189	209,633
7	Дархан-Уул	16	3,453,874	215,867
8	Дорноговь	12	1,321,637	108,668
9	Дорнод	9	1,597,986	173,694
10	Дундговь	9	1,340,170	151,400
11	Завхан	8	793,144	95,648
12	Орхон	10	2,580,320	271,613
13	Өвөрхангай	8	817,396	97,237
14	Өмнөговь	9	418,136	48,379
15	Сүхбаатар	9	2,008,785	227,514
16	Сэлэнгэ	17	1,548,285	93,030
17	Төв	12	1,366,456	113,871
18	Увс	29	3,363,168	115,226
19	Ховд	7	1,023,145	143,880
20	Хөвсгөл	30	1,792,927	59,270
21	Хэнтий	19	3,655,193	197,264
	Нийт	15	1,861,981	126,153



2. Даатгалын компаниудын борлуулалтын үр дүн

Даатгалын компаниудын борлуулалтын үр дүнг авч үзвэл нийт 13 317 малчин өрхийг даатгалд хамруулснаас 28 хувийг “Бодь даатгал” ХХК, 25.8 хувийг “Монгол даатгал” ХХК, 15.7 хувийг “МИГ даатгал” ХХК, 15.3 хувийг “Практикал даатгал” ХХК, 12.3 хувийг “Тэнгэр даатгал” ХХК, 3 хувийг “Монре даатгал” ХХК тус тус эзэлжээ.

График №4. Даатгалд хамруулсан малчин өрх, дүнд эзлэх хувиар



Хүснэгт №5. Даатгалын компаниудын борлуулалтын тоо (аймгаар, 2015 он)

№	Аймгийн нэр	Монгол	Бодь	Тэнгэр	Практикал	Монре	МИГ	Нийт
1	Архангай	74	259	18	20	0	231	602
2	Баян-Өлгий	61	68	102	10	0	1	242
3	Баянхонгор	1,093	626	317	568	0	26	2,630
4	Булган	14	164	0	48	0	32	258
5	Говь-Алтай	86	61	95	52	0	63	357
6	Говьсүмбэр	23	0	0	0	0	0	23
7	Дархан-Уул	0	19	0	0	13	0	32
8	Дорноговь	29	207	0	128	0	86	450
9	Дорнод	43	22	8	81	30	0	184
10	Дундговь	132	123	0	39	22	162	478
11	Завхан	110	198	122	31	0	78	539
12	Орхон	0	6	0	0	0	13	19
13	Өвөрхангай	82	68	31	73	0	15	269
14	Өмнөговь	77	0	2	8	27	7	121
15	Сүхбаатар	190	81	43	47	0	1	362
16	Сэлэнгэ	70	127	0	36	0	0	233
17	Төв	0	73	0	153	0	206	432
18	Увс	214	554	49	172	194	218	1,401
19	Ховд	60	85	40	54	17	0	256
20	Хөвсгөл	37	34	9	2	2	400	484
21	Хэнтий	270	113	429	57	0	76	945
	Нийт	2,665	2,888	1,265	1,579	305	1,615	10,317



2015 оны борлуулалтаар нийт 1 301 сая төгрөгний борлуулалт хийсний 29,9 хувийг Монгол даатгал, 28,2 хувийг Бодь даатгал, 12,7 хувийг Тэнгэр даатгал, 13,8 хувийг Практикал даатгал, 2,9 хувийг Монре даатгал, 12,4 хувийг МИГ даатгал компани тус тус эзэлжээ. МИД-ын 2015 оны борлуулалтын орлогын хэмжээг оролцогч даатгалын компани тус бүрээр харуулбал:

Хүснэгт №6. Даатгалын компаниудын МИД-ын хураамжийн орлого (сая төгрөгөөр, 2015 он)

№	Аймгийн нэр	Монгол	Бодь	Тэнгэр	Практикал	Монре	МИГ	Нийт
1	Архангай	10.0	13.6	1.9	2.1	-	10.7	38.2
2	Баян-Өлгий	7.1	5.2	8.2	2.0	-	0.2	22.7
3	Баянхонгор	139.5	87.9	33.9	65.5	-	3.3	330.1
4	Булган	2.0	17.4	-	7.8	-	5.6	32.8
5	Говь-Алтай	14.1	10.1	19.0	4.7	-	9.5	57.4
6	Говьсүмбэр	4.8	-	-	-	-	-	4.8
7	Дархан-Уул	-	3.2	-	-	3.7	-	6.9
8	Дорноговь	4.3	27.0	-	11.1	-	6.5	48.9
9	Дорнод	8.4	4.8	2.3	12.9	3.5	-	32.0
10	Дундговь	31.2	14.5	-	5.4	4.0	17.3	72.4
11	Завхан	11.3	21.8	8.9	2.9	-	6.6	51.6
12	Орхон	-	1.2	-	-	-	4.0	5.2
13	Өвөрхангай	6.7	8.6	2.4	6.3	-	2.2	26.2
14	Өмнөговь	3.5	-	0.6	0.7	0.8	0.3	5.9
15	Сүхбаатар	41.2	24.7	6.4	9.9	-	0.3	82.4
16	Сэлэнгэ	6.2	12.5	-	3.0	-	-	21.7
17	Төв	-	11.3	-	10.3	-	27.6	49.2
18	Увс	23.2	64.8	6.3	13.8	22.9	30.4	161.4
20	Ховд	7.2	12.7	6.6	7.7	2.6	-	36.8
21	Хөвсгөл	3.3	3.4	1.2	1.5	0.1	19.2	28.7
22	Хэнтий	65.6	22.8	67.3	12.2	-	18.5	186.4
	Нийт	389.4	367.6	165.1	179.7	37.6	162.0	1,301.5

Өнгөрсөн оны борлуулалттай харьцуулахад даатгалд хамрагдсан малчин өрхийн тоо 26.7 хувь, хураамжийн орлого 4.1 хувиар буурсан ба зөвхөн Миг даатгал компанийн борлуулалтын орлого 36,8%-аар өсөж бусад даатгалын компаниудын хураамж орлого буурсан дүнтэй байна.




Хүснэгт №7. Даатгуулагчдын тоо ба хураамжийн орлогын 2014 оны борлуулалттай харьцуулсан дүн (даатгалын компаниар)

№	Компани	Даатгасан малчин өрх	2014 оны борлуулалт	Өсөлт /бууралт/-ийн хувь	Хураамжийн орлого	2014 оны борлуулалт	Өсөлт /бууралт/-ийн хувь
1	Монгол даатгал	2665	3721	-28.38%	389,423,555₮	426,592,859₮	-8.7%
2	Бодь даатгал	2888	4254	-32.11%	367,648,170₮	416,058,288₮	-11.6%
3	Тэнгэр даатгал	1265	2032	-37.75%	165,081,010₮	171,659,645₮	-3.8%
4	Практикал даатгал	1579	2252	-29.88%	179,740,831₮	186,633,186₮	-3.7%
5	Монре даатгал	305	337	-9.50%	37,611,041₮	37,764,032₮	-0.4%
6	МИГ даатгал	1615	1493	8.17%	162,020,303₮	118,439,253₮	36.8%
Нийт		10317	14089	-26.77%	1,301,524,910₮	1,357,147,263₮	-4.1%

2015 оны борлуулалтын улиралд 1,805 даатгалын төлөөлөгч МИД-ыг борлуулах эрх авснаас 699 төлөөлөгч борлуулалт хийж үр бүтээлтэй ажилласан бол 1106 даатгалын төлөөлөгч борлуулалт хийгээгүй байна.

График №5. Борлуулалт хийсэн болон борлуулалт хийгээгүй даатгалын төлөөлөгчдийн тоо (даатгалын компаниар)





3. ЭРСДЭЛ САНХҮҮЖҮҮЛЭХ ЧАДАВХИ

2015 оны борлуулалтын улиралд 1.3 тэр бум төгрөгийн хураамж төвлөрүүлж дунд болон дээд түвшинд давхар даатгуулсаны үр дүнд дунд түвшинд Хамтын эрсдэлийн сан, дунд түвшний нөөц болон олон улсын давхар даатгал нийлээд 2,4 тэрбум, дээд түвшинд дээд түвшний нөөц болон олон улсын давхар даатгал нийлээд 1 тэрбум, нийт алдагдлаас хамгаалах сангийн хөрөнгөөс эх үүсвэр татахгүйгээр 3.4 тэрбум төгрөгийн эрсдэлийг даах хүчин чадалтай болоод байна.

Нийт даатгалын хураамж	1,313,446,762.56
Нийт сонгосон үнэлгээ	27,729,337,218.14
Эрсдэлийн дунд түвшин	
Хамтын эрсдэлийн сан	591,051,043.15
Дунд түвшний нөөц	65,672,338.13
ОУ Давхар Даатгал-дунд	<u>1,707,480,791.33</u>
	2,364,204,172.61
Эрсдэлийн дээд түвшин	
Дээд түвшний нөөц	83,188,011.65
ОУ Давхар даатгал-Дээд	<u>945,570,399.14</u>
	1,028,758,410.79
Нийт эрсдэл даах чадвар	3,392,962,583.40




4. Дүгнэлт

2015 оны борлуулалтын улирлын явц, үр дүн, даатгалын компанийн салбарууд болон зарим малчдын санал дүгнэлтээс үзвэл МИД-ын үйл ажиллагаа нь Малын индексжүүлсэн даатгал төслөөс “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-руу шилжих шилжилтийн үйл ажиллагаатай холбоотойгоор борлуулалтын улирал хугацаандаа эхлээгүй, орон нутагт хариуцсан ажилтангүй болсон зэргээс зарим малчдад малын даатгал хийгдэхээ больсон гэх ташаа мэдээлэл хүрч, борлуулалт тодорхой хувиар буурахад нөлөөлсөн байна.

Мөн сүүлийн хэдэн жилийн цаг агаарын таатай байдал нь малчдын эрсдэлээс хамгаалах сэдлийг бууруулж, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд хамгийн түрүүнд танах зардал болгоход хүргээд байна. 2010-2014 онд даатгуулсан малчин өрхүүд цаг агаарын таатай нөхцлийн улмаас олон жил дараалан даатгуулсан ч нөхөн төлбөр аваагүй, эсвэл маш бага хэмжээгээр авсан нь даатгуулах эсэхдээ эргэлзэж байж даатгуулсан зарим малчдыг дахин даатгуулахгүй байхад хүргэж, нийт аймгуудын хэмжээнд борлуулалтыг буурахад хүргэж байна.

График №7.Олгосон нөхөн төлбөрийн хэмжээ (2006-2015, сая.төг-өөр)



“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн зүгээс үйл ажиллагаа жигдэрч эхэлсэнээс хойш борлуулалтыг идэвхжүүлэх, компанийн үйл ажиллагааг сурталчлах ажлыг эрчимтэй хийсэн бөгөөд ирэх 2016 оны борлуулалтыг өсгөх тал дээр тодорхой ажлуудыг төлөвлөн, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлээд байна. Жишээлбэл, МИД-ыг дан ганц даатгалын төлөөлөгчдөөр биш зуучлагч арилжааны банкаар дамжуулан борлуулах талаар хэлэлцээр хийгдэж байгаа бөгөөд урьдчилсан тооцооллоор арилжааны банкуудаас зээл авч байгаа малчдын 30%-ийг даатгалд хамруулна гэж үзвэл 9 500 орчим малчинтай гэрээ байгуулах боломжтой юм. Мөн сумдын зарим албан тушаалтны ажил үүргийн хуваарьт МИД-ын хэрэгжилтийг хангах талаар оруулж, үр дүнг нь бодитой дүгнэдэг байхаар холбогдох газруудтай харилцаж эхлээд байна.